



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/173

Мандалговь

Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1, Сангийн сайдын 2018 оны 228 дугаар тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 7.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөх, арга зүйн зөвлөмж өгч дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Н.Эрдэнэ-Очир (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)

Нарийн бичгийн дарга: О.Шинэжаргал (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн эдийн засгийн бодлого төлөвлөлт хариуцсан ерөнхий эдийн засагч, ахлах мэргэжилтэн)

Гишүүд: А.Ганбат (Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга)  
Н.Сүхбаатар (Санхүү төрийн сангийн хэлтсийн ахлах мэргэжилтэн)

С.Энхжаргал (Төсвийн ерөнхий санхүүч)  
О.Мөнхзул (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн барилга хот байгуулалт, дэд бүтцийн бодлого хариуцсан мэргэжилтэн)

Б.Ууганцэрэн (Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэн)

Д.Нэргүй (Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Э.Уянга (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын Газар, газрын хэвлий, түүний баялгийн ашиглалт, нөхөн сэргээлт, хөрсний доройтол /цөлжилт/, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хариуцсан мэргэжилтэн)

48819046"

Ж.Шинэ-Уянга (Хөдөө аж ахуйн газрын малын бэлчээр, тэжээл, усан хангамж хариуцсан мэргэжилтэн)

О.Баярсайхан (Аймгийн ИТХ-ын төлөөлөгч)

Б.Энхтүвшин (Тогтвортой амьжиргаа-3 төслийн Дундговь аймаг дахь төслийн ажилтан)

Б.Ням (МҮХАҮТ-ийн Дундговь аймаг дахь салбар танхимын дарга)

Хоёр. Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалтыг гаргаж олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулан олон нийтийн эрх ашигт нийцсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, холбогдох журмын шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган танилцуулахыг ажлын хэсэг (Н.Эрдэнэ-Очир)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ